





Зураг 4

Хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, 2010 оны эхний 2 сарын байдлаар, хувиар



Зураг 5

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, тэрбум төг



Улсын хэмжээнд 2010 оны эхний 2 сард 19.1 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 1.6 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 7810 буюу 29.1 хувь, баривчлагдсан хүний тоо 555 буюу 25.7 хувиар буурчээ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 38.9 хувь нь гэр, орон сууцанд, 18.0 хувь нь гудамж талбайд, 14.2 хувь нь олон нийтийн газарт, 1.3 хувь нь нийтийн тээвэрт, 2.7 хувь нь төрийн байгууллагад, 2.1 хувь нь төрийн бус байгууллагад, 4.4 хувь нь аж ахуйн нэгжид, 4.5 хувь нь авто зам дээр, 13.9 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 2010 оны эхний 2 сард 727 хүн гэмтэж, 297 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 486 буюу 40.1 хувиар буурч, нас барсан хүний тоо 11 буюу 3.8 хувиар нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2010 оны эхний 2 сард 2491.3 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 855.3 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 7304.0 сая төг буюу 74.6 хувь, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 66.0 сая төг буюу 7.2 хувиар буурсан байна (Зураг 5).

Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 1872.3 сая төг буюу 75.2 хувь нь хувийн өмчид ногдож байна. Гэмт хэргийн улмаас нийт 2764 иргэн хохирсны 159 буюу 5.8 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 977 буюу 35.3 хувь нь эмэгтэйчүүд, 170 буюу 6.2 хувь нь өөрийн буруугаас хохирсон иргэд байна.

Гэмт хэргийн улмаас нийт 92 байгууллагад хохирол учирсны 60 нь төрийн байгууллага, 24 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, 8 нь төрийн бус байгууллага байна.